



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.10 № 01/11

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ХАТАНБААТАР  
ТАНАА

Г Зөрчил арилгуулах тухай

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн яам тендерээр сонгон шалгаруулсан "Лаб тех" ХХК 827.0 сая төгрөгийн томографийн аппаратыг Улсын II төв эмнэлэгийн 2012 оны санхүүгийн тайлангийн аудит хийх явцад нийлүүлэхээр гэрээлсэн боловч дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Гэрээнд заасан нийлүүлэх хугацааг 30 хоногоор хоцроосон,
- Хугацаа хоцроосноос хамаарч 16.5 сая төгрөгийн алданти тооцоогүй,
- Аппарат 1 сар гаруй хугацаанд ажиллаад эвдэрсэн, үүнээс хойших хугацаанд хийгдэх төлөвлөгөөт ажил алдагдсан,
- Баталгаат хугацаандаа засвар бүрэн хийгээгүй,
- Техникийн шаардлага хангаагүй тул захиалагч хүлээлцсэн акт үйлдээгүй,
- Гэрээний үр дүнг тооцоогүй байна

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.6-д "бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих", 57.3-т "Тендерт оролцогч болон аливаа этгээд нь худалдан авах гэрээний үүргээ зөрчсөн, биелүүлээгүй" гэсэн заалтууд,

Тендерийн гэрээний 17 дугаар зүйлийн 1-т "Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн гэрээний тусгай нөхцөлд заасан 1 долоо хоног тутамд 0,5 хувьтай тэнцэх алданги оногдуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн албан шаардлагыг өгч байна.

070029

Дээрх 827.0 сая төгрөгийн хөрөнгийг хэвийн үйл ажиллагаанд оруулж засуулан, 16.5 сая төгрөгийн алданги тооцож биелэлтийг 2013 оны эхний хагас жилд багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хатанбаатар, хариуцсан албан тушаалтан, мэргэжилтэн нарт даалгав.

АУДИТОР



Б. ДАВААБААТАР